

ГАДААДААС АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТЭН АВАХ АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГУУДЫН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

№	Бүрдүүлэх материал	Тайлбар
1	Албан бичиг /хүсэлт дэлгэрэнгүй/	Байгууллагын тухайн онд гүйцэтгэх төсөл хөтөлбөрийн тухай товч мэдээлэл, гадаадын иргэдийг ажиллуулах болсон шалтгаан, тэдгээрийн хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, гадаадаас авах ажиллах хүчний тоо хэмжээ, улсын нэр, ажил гүйцэтгэх хугацааны хуваарь, төсөл хэрэгжих байршил зэргийг агуулсан байх
2	Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар	/нотариатчаар баталгаажуулах шаардлагагүй/
3	Тусгай зөвшөөрлийн хуулбар	/хүчин төгөлдөр зөвшөөрөл, гэрээний хамт/
4	Тухайн онд хэрэгжүүлэх төсөл бүтээн байгуулалтын ажилтай холбоотой материал	“Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль”-ийн 7.3 дахь заалтад хамаарах, төсөл, бүтээн байгуулалтын ажлын хөрөнгө оруулалттай холбоотой мэдээлэл, тухайн төсөл, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх талаар хийгдсэн гэрээ / <i>нотариатаар баталгаажуулсан</i> / захиалагч бол тухайн ажлын талаар товч танилцуулга, туслан гүйцэтгэгч бол захиалагчтай хийсэн гэрээний хуулбар / <i>нотариатаар баталгаажуулсан</i> /
5	Өмнө нь Засгийн газрын тогтоол, ХНХ-ын сайдын тушаалд хамрагдаж байсан эсэх, түүний гүйцэтгэлийн мэдээ	Өмнө нь гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулж байсан бол урьдчилсан зөвшөөрөл олгосон тогтоол, тушаал, шийдвэрийн биелэлтийн талаарх мэдээлэл, хэдэн хүний урьдчилсан зөвшөөрөл гаваад, хэдэн хүн Монгол Улсад хөдөлмөр эрхэлсэн тухай / <i>урьдчилсан зөвшөөрлөөс цөөн хүн ажилласан тохиолдолд түүний шалтгаан</i> /
6	Гадаадаас ажиллах хүч нийлүүлэх талаар гадаадын хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасан ерөнхий нөхцөлүүдийг тусгасан / <i>гэрээний эх хувь болон баталгаат орчуулгын товчооны орчуулгатай</i> /
7	Салбарын яам, агентлагийн тодорхойлолт	Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийн харъяалах яам, агентлагийн тус салбарт гадаадын ажиллах хүч ажиллуулж болох тухай тодорхойлолт
8	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /хэлтэс/-ын тодорхойлолт	Аж ахуйн нэгж байгууллагын тухайн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл хэрэгжих аймаг, дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар болон хэлтсийн тодорхойлолт
9	Дотоодоос ажиллах хүч авах ажлын байрны захиалга /ААНБ-ын албан тоотгоор/	Тухайн төсөлд шаардлагатай дотоодоос авах ажилтан тоо хэмжээ, ямар ажлыг гүйцэтгэх, мэргэжлийн чиглэл, хугацааны хуваарь
10	Гадаадын иргэн, харьяатын газрын тодорхойлолт	Тухайн аж ахуйн нэгж байгууллага нь өмнө Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулахдаа нэвтрэх, оршин суух, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл холбоотой ямар нэгэн зарчил гаргаагүй тухай
11	Нийгмийн даатгалын тайлан	Маягт НД-7, Маягт НД-8-уудаар гаргасан сүүлийн сарын тайлан, нотариатаар баталгаажсан
	Шаардлагатай бол бусад	Нэмэлт шаардлагатай материал